

**БАЛДАНЫ СОДНОМЫН ГУРВАН БОТЬ БУЮУ
ХХ ЗУУНЫ ОЮУН СЭТГЭЛГЭЭ**

Г. Галбаяр *

Их сэтгэж, их ажиллаж, их бүтээсэн ч цагийн шуурга, зарим хүний мөс чанараас хамаарч далд дурсагдаж, ил бага яригдсан нэгэн бол ХХ зууны соён гэгээрүүлэгч, монголын утга зохиол судлаач, Д. Нацагдоржийн нэрэмжит шагналт, эрдэмтэн зохиолч Балданы Содном авгай билээ. Тэрбээр шинэ цагийн монголын манлай сэхээтнүүд болох Д. Нацагдорж, Ц. Дамдинсүрэн, С. Буяннэмэх, Б. Ринчен нартай мөр зэрэгцэн сурч боловсорч, хийж бүтээж, ажиллаж амьдарч явсан юм.

Б. Содномын мэндэлсний 90 жилийн ойгоор “Б. Содномын намтар, бүтээлүүд” хэмээх түүний зохиол, судалгаа шинжилгээний бүтээлийн анхны эмхэтгэл, таньж мэдэх хүмүүсийнх нь дурсамж дургалын түүвэр хэвлэгдсэн юм. Эл ном цөөн хувь хэвлэгдсэнээр олны хүртээл болж чадаагүй төдийгүй Б. Содномын бичиж туурвисан, эмхэтгэн цуглуулсан зүйлүүдийг тэр бүр бүрэн агуулж чадаагүй. Энэ бүх нөхцөл байдал болоод Б. Содномын үеийн үед дурсагдах бүтээл туурвилын чанар, цар хүрээ, эрт урьдын үүх түүх, тус дэмийг санан нас сүүдэр зуун зэрэгцсэнийг нь тохиолдуулан үр хүүхдүүдийнх нь санал санаачлага, тус дэмийг авч Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн, Хэлбичгийн шинжлэх ухааны доктор, профессор Дожоогийн Цэдэв хэвлэн нийтлүүлсэн бүхнийг нь сонин сэтгүүл, архивын шарласан хуудаснаас шүүрдэн олж, гар бичмэл эхтэй нь тулган нягталж, хэвлүүлээгүй зарим бүтээлийг нь нэмэн оруулж, удиртгал бичиж, бүтээлийн жагсаалт, тайлбар үйлдэн, хэвлэлд бэлтгэж, ариутган шүүж, ГУРВАН БОТЬ (“ЗОХИОЛ СУДЛАЛ” I боть 872 тал хуудас буюу 54,2 хэвлэлийн хуудас. “Д. НАЦАГДОРЖ СУДЛАЛ” II боть 614 тал хуудас буюу 38,5 хэвлэлийн хуудас. “ТҮҮВЭР БҮТЭЭЛ” III боть 832 тал хуудас буюу 52 хэвлэлийн хуудас)-иор хэвлүүлсэн байна.

Д. Цэдэв өнгөрсөн түүхэн дэх бичиг үсэг солигдсон, төр засгийн бодлого шийдвэр, уншигч олны итгэл сэтгэлийн өөрчлөлт гээд олон зүйлээс болж, тэнгэрийн ивээл, цагийн бошгоор төрсөн их сэтгэгчид болох Д. Нацагдорж, Ц. Дамдинсүрэн, С. Буяннэмэх нарын бүтээл туурвил жинхэнэ эхээрээ бус ямар нэгэн хэмжээгээр их бага засвартайгаар, түүгээр ч барахгүй хоорондоо болоод бусдын зохиол бүтээлтэй холилдож солигдож ирснийг тус бүрийнх нь гар ноорог эхтэй тулгаж, үнэн мөнөөр нь сэргээн шинээр хэвлүүлэх нэн хүнд хэрнээ буянтай ажлыг гүйцэтгэж яваа нэгэн гэдгийг

* МУИС-ийн Монгол хэл, соёлын сургуулийн Утга зохиолын тэнхим

монголчууд хотлоороо мэднэ. Энэ удаа Б. Содном ахайтны номон суврагыг сүндэрлүүлжээ. Үүнд:

“ЗОХИОЛ СУДЛАЛ” хэмээх тэргүүн ботид эрхлэн хэвлүүлэгчийн бичсэн “Балданы Содномын шинжилгээ-уран сайхны сэтгэлгээний ертөнц” гэсэн томоохон удиртгалаас гадна “Аман зохиол судлал”, “Утга зохиолын онол”, “Утга зохиолын түүхэн судлал” гэсэн үндсэн гурван бүлэг багтсан байна.

“Аман зохиол судлал” хэмээх тэргүүн бүлэгт Б. Содномын бичсэн ардын аман зохиол гэж юу болохоос авахуулаад аман зохиолын төрөл зүйл, тэдний хоорондын учир холбогдол зэргийг тайлбарлан бичсэн онолын өгүүллүүд болоод сурвалжлан цуглуулсан монгол аман зохиолын үнэт өв сангаас оруулжээ. Судлаач өөрийн бичсэн зүйлийг баталгаажуулах үүднээс сурвалжлан цуглуулсан монгол аман зохиолын их өв сангаасаа тухай бүр нь жишээ баримт болгон оруулсан байдаг нь уг түүвэрт хэвлэгдсэн байна. Тийм ч учраас эл түүврийг эрхлэн хэвлүүлэгч “*Цаг цагийн урсгалд улам бүдгэрч, тэр ч атугай зарим нь арилж устаж байгаа аман зохиолын олон төрлийг ёс дэгтэй нь авч үлдэх нь хойч үедээ өвлүүлж байгаа нөөц баялаг хэмээн үзэж болно*” (15 дугаар тал) хэмээн онцлон тэмдэглэсэн байхад академич П. Хорлоо “*Б. Содном бол утга зохиол судлах үндсэн мэргэжилтэй. Ийм болохоор утга зохиолын эх булаг болсон ардын аман зохиолыг гүнзгий судалсан эрдэмтэн. Тэрбээр ард олны ам дамжин яригдаж байгаа үлгэр домог, зүйр цэцэн үгийн баялаг материалыг биеэр цуглуулан судалж судалгааны хүрээнд оруулсан байна.*” (Балданы Содном “Түүвэр бүтээл” Гутгаар боть. Уб., 2008-2009. 690 дүгээр тал) хэмээн Б. Содномын монгол аман зохиолын судлалд оруулсан гавьяаг үнэлсэн байдаг нь учиртай.

“Утга зохиолын онол” хэмээх дэд бүлэгт Б. Содномын шинэ цагийн монголын уран зохиолын онолын сэтгэлгээнд оруулсан үнэтэй хувь нэмэр болох бүтээлүүдийг оруулжээ. Ленинград, Москвад байхдаа уран зохиолын онолд суралцсанаа үндэс болгож “Утга зохиолын тухай” (1934), “Үргэлжилсэн зохиолын учир” (1938), “Зохиолын явдал хэмээгч юун буй?” (1944), “Монгол шүлгийн арга маяг” (1956) зэрэг шинэ сэргэг амьсгалтай онолын өгүүллүүд бичиж нийтлүүлснээрээ эрдэмтэн Д. Цэндийн үнэлснээр “*Уран зохиолын онолын салбарт уран зохиол судлагч Б. Содномын бичсэн өгүүллүүд өөрийн байртай юм.*” (“Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэлийн тойм” Уб., 1966. 11 дүгээр тал) Өрнөдийн тэр дундаа оросын уран зохиолын онолын талаар тухайн үедээ манайхнаас хамгийн гүнзгий мэдлэгтэй нь тэр байсныг С. Буяннэмэхийн түүнд хандаж “*Би бол дорно дахины уран зохиолын зарим төдий онолыг үзэж, өөрийн хар ухаандаа ойлгохуйц болж, дэмий л дууриаж бичих юм. Европ зүгийн уран зохиолын онолтой танилцах бололцоо над олдсонгүй. Би ердөө ч ямар нэг уран зохиолын тухай багшлуулж яваагүй. Үзэж уншаад л иймэрхүү байдаг юм уу даа гэж боддог. Иймд товч боловч европын утга зохиолын тухай ч гэх юм уу даа, аль ямар ямар зохиолын зүйл байдаг, түүний тухай холбогдох онол нь ямар вэ? гэдгийг надад ярина уу?*” гэсэн хүсэлт гаргаж байснаас тодорхой харагдана. С. Буяннэмэхийн хүсэлтийн дагуу түүнд тэрээр “*Би ер нь европын утга зохиолын онолыг танаас илүү мэдэхгүй байх аа. ... Гэвч би заалгасан хичээлийг үндэслэж, өөрийн ойлгосон зүйлээс ярьж*” гээд “*... уран зохиолын гол гурван төрөл, нэг төрлийн доторх хэлбэр буюу зүйлийг, дор бүрийн тойм онолтой танилцуулж, шүлгийн хэмжээний бүдүүвчийг ...*” бас романы тухай, зохиолын зохион байгуулалтын талаар дэлгэрэнгүй ярьж өгч байсан байна. (Б. Содном “Манай ахмад зохиолчид”. Утга зохиолын хөгжлийн асуудлууд. Уб., 1971. 230-231 дүгээр тал) Энэ нь Б. Содном тухайн үедээ өрнөдийн уран зохиолын

онолыг хамгийн сайн мэддэг байсныг харуулна. Тийм ч учраас манайд хамгийн анх “Утга зохиолын нэр томъёо” (1956)-г бүртгэн хийж, залгуулаад “Утга зохиолын нэр томъёоны товч тайлбар” /“Зарим үгийн товч тайлбар”/ (1957)-ыг бичсэн нь монголын уран зохиолын онолын сэтгэлгээнд чухал хувь нэмэр болсныг хэн ч үгүйсгэх аргагүй. Монгол угсаатнууд ч европ дахины утга зохиолын онолын сэтгэлгээтэй дамжин танилцсан. Б. Содномын бичсэн дээрхийн зэрэг уран зохиолын онолын өгүүлэлүүд, тайлбар толь зэргийг энэ ботид анх хэвлэгдсэн эх, гар ноорог хоёрыг нь тулган нягталж хэвлүүлжээ.

“Утга зохиолын түүхэн судлал” гэсэн гутгаар бүлэгт Б. Содномын монгол үндэстний бичгийн уран зохиолын хөгжил хувьсал хэрхэн явж ирсэнд зориулагдаж байсныг оруулсан байна. Монгол аман зохиолоос салбарлан мөчирлөж хөгжсөн монголын бичгийн уран зохиол, тэр дундаа гол төлөөлөл, төлөөлөгчид болох “Монголын нууц товчоо”, XIII-XIV зууны үеийн монгол уран зохиолын онцлог, шинэ цагийн монголын уран зохиолын хөгжил, В. Инжаннаши, Д. Равжаа, Зая бандид Намхайжамц, Д. Нацагдорж, Ц. Дамдинсүрэн, Ши. Аюуш, Ч. Лодойдамба, Төвдийн шүлэгч Мялрайба, Оросын зохиолч М. Горький, Н. В. Гоголь нарын тухай дэлгэрэнгүй бичсэн ажээ. Тэр дундаа түүний бичсэн “Монголын утга зохиолын хөгжлийн түүхчилсэн төлөв” (1946) бүтээл нь тухайн үеийн буюу 1940-өөд оны монголын уран зохиол судлалын хамгийн доривтой томоохон бүтээл болж байсан юм. Гэвч энэ бүтээл нь “феодалын нийгмийг монголын түүхийн “алтан үе” байсан мэтээр бичсэн” зэргээр буруутгагдан хэлмэгдэлд өртөж байсан ч хожмын судлаачдад “Б. Содномын төлөв нь олон тооны сонирхолтой баримтуудыг агуулсан, зарим бичмэл түүхэн зохиол, хувьсгалын өмнөх үед хамаарах дээдсийн утга зохиол, орчин үеийн утга зохиолын үүсэл хөгжлийн түүхийн нилээд нотолгоо, хувьсгалын үеийн зохиолчдын уран бүтээлийн тухай гэх мэт урьд өмнө мэдэгдээгүй ихээхэн мэдээлэл сэлт багтаасан нягт нямбай ажил болсон юм”(Г. И. Михайлов. “Очерк истории современной монгольской литературы” Изд. АН СССР. Москва., 1955. стр. 170-171), “Тус өгүүлэл нь Монголын эрдэмтдийн дотроос эх хэл дээр бичигдсэн монгол уран зохиолын хөгжлийн түүхэн тоймыг тодруулан гаргаж бичсэн хамаг анхны судалгааны доривтой бүтээл болох юм” (Ван Мандуга “Монголын орчин үеийн уран зохиолын онол шүүмжлэлийн судлал. Үндэсний хэвлэлийн хороо. Бээжин., 2003. 131 дүгээр тал”) гэх зэргээр үнэлэгдсэн түүхтэй.

“Д. НАЦАГДОРЖ СУДЛАЛ” хэмээх дэд ботид түүний бичсэн “Д. Нацагдоржийн намтар, уран бүтээлийн тухай нэгэн сэдэвт зохиол”, “Д. Нацагдоржийн зарим уран зохиолын судалгаа”, “Д. Нацагдорж судлалаар эрдмийн зэрэг хамгаалсан түүх”, “Д. Нацагдоржийн намтар, зохиолын холбогдолтой өгүүлүүдийн цоморлиг” гэсэн хэсэг бүлгүүд багтсан байна. Монголын уран зохиол судлал, тэр дундаа Германд хамт суралцаж байсан Дашдоржийн Нацагдоржийн намтар бүтээлийг сурвалжлан олох, цуглуулах, судлах, нийтлэхэд Б. Содном судлаач бүхий л амьдралаа бүрэн дүүрэн зориулсан юм. “Хэл бичгийн кабинетийн ажилтан Б. Содномын 1954 оноос 1958 оныг дуустал хийсэн ажлын тойм” гэсэн гарчигтай гар бичмэлийн “1954 онд.”-ын 3 дугаарт “Д. Нацагдоржийн зохиосон уран зохиолын зүйлсийг сурвалжлан эрэх ажлыг эхлэж, 1921 оноос 1930 он хүртэлх хэвлэлийг шүүрдэв” хэмээсэн бол “1955 онд.”-ын 2 дугаарт “Д. Нацагдоржийн уран зохиолын түүвэр хийх ажлыг үргэлжлүүлж, 1930-аас 1937 оныг дуусталх хэвлэлийг шүүрдэн, энгийн хүмүүс, түүний хамаатан, садан зэргээр сурвалжлан эрэв”, мөн “1957 онд.”-ын 4 дүгээрт “Д. Нацагдоржийн зохиосон “Их

авхай”, “Нуугдсан эрдэнэ” гэдэг хоёр жүжгийн гар бичмэлийн татлагааг өсгөдөг шилээр уншиж, шинэ үсгээр машиндуулав” (Балданы Содном “Зохиол судлал” Тэргүүн боть. Уб., 2008-2009. 16 дугаар тал) гэсэн байдаг байна. Энэхүү жишээ баримтууд түүнийг “Д. Нацагдорж судлал”-ыг хөгжүүлэхэд хэрхэн хүчин зүтгэснийг батлан харуулна. Б. Содном их зохиолч Д. Нацагдоржийн намтар, бүтээлийг бүрэн эхээр нь сурвалжлан цуглуулж, эмхэтгэн цэгцлээгүй бол “Д. Нацагдорж судлал”, улмаар монголын уран зохиолын судлал өнөөдөр өдий зэрэгт хүрсэн байж чадах уу? гэдэг асуудал ч урган гарахыг үгүйсгэх аргагүй. Судлаач Б. Содном Д. Нацагдоржийн бүтээл туурвилыг сурвалжлан цуглуулж, эмхэлж цэгцлээд зогсохгүй дотоод мөн чанарт нь авьяастай, боловсролтой, туршлагатай судлаачийн үүднээс ярган орж, Д. Нацагдоржийн, цаашлаад монголчуудын уран сайхны сэтгэлгээний ертөнцийн мөн чанар, өнгө төрхийг задлан гаргаж тодруулсан байдаг. Д. Нацагдоржийн уран бүтээлийн яруу сайхан, далд нууцлаг увдисыг багтаасан энэ ботиос уншигч судлаач хэн бүхэн нэгийг олж, хоёрыг сэтгэнэ гэдэгт эргэлзэх хэрэггүй.

“ТҮҮВЭР БҮТЭЭЛ” хэмээх гутгаар ботид “Хэл шинжлэл, нэр томьёо судлал”-аар бичсэн өгүүлэлүүд, өөрийнх нь бичсэн шүлэг найргаас эхлүүлээд хүүрнэл зохиолууд, “Өгүүлэл, тодорхойлолт, дурсамж, сэтгэмж” гэсэн түүний бичсэн элдэв дурсамж, яриа хөөрөө, дурдатгалууд, орос, герман хэлнээс хийсэн орчуулгууд, Б. Содном судлалд холбогдох намтар, баримт бичиг, захидал, дурсамж, судалгаанууд хэвлэгдсэн байна. Төгсгөлд нь Б. Содномын “Өдрийн тэмдэглэлийн дэвтэр”-ийн зарим зүйлээс оруулаад, дараа нь ботийг эрхлэн хэвлүүлсэн профессор Д. Цэдэвийн хийсэн “Балданы Содномын бүтээлийн жагсаалтыг” хавсаргажээ.

Б. Содном ажил амьдралынхаа олон жилийг шинэ цагийн монголын шинжлэх ухааны салбар бүрийн нэр томьёог зохиох, тогтоох, судлан шинжлэхэд зориулсан нэгэн. Тийм ч учраас түүний бүтээл туурвилын энэ гурван ботийн удиртгал болох “Балданы Содномын шинжилгээ-уран сайхны сэтгэлгээний ертөнц” хэсэгт эрдэмтэн Д. Цэдэв “Б. Содном, Монголын Шинжлэх ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнгийн нэр томьёоны секторын эрхлэгч, улсын нэр томьёоны комиссын нарийн бичгийн даргын албыг олон жил хашигдаа салбар салбарын нэр томьёог зөв тогтоох, нэр томьёо судлалыг хөгжүүлэхэд нойр хоолоо умартан зүтгэснийг түүнтэй нэр томьёоны толь дээр хамтарч ажиллаж байсан эрдэмтэд мартаж аргагүй” (“Зохиол судлал” Тэргүүн боть. 22 дугаар тал) хэмээн онцлон өгүүлсэн байна. Эрхлэн хэвлүүлэгчийн энэ үзлийг “Б. Содном олон шинжлэх ухааны нэр томьёог боловсруулах ажилд насан туршидаа зүтгэсэн хүн, анагаах ухааны салбарын: анагаах ухааны нэр томьёо (1953), биеийн тамирын нэр томьёо (1957), хэвийн физиологи (1964), арьс өнгөний өвчин (1967), чих хамар хоолойн өвчний нэр томьёо (1969), нүдний өвчний нэр томьёо (1969), дотор өвчний нэр томьёо (1973), эх барих эмэгтэйчүүдийн нэр томьёо (1964), эх барих эмэгтэйчүүд судлал (1969), хүний өвчний ерөнхий нэр (1967), нүүр амны өвчний нэр томьёо (1975) зэргийг боловсруулахад хамтран оролцжээ. Үүнээс үзэхэд Б. Содном бол Анагаах ухааны нэр томьёог үндэслэгчдийн нэг, амьдралын турши анагаах ухааны нэр томьёог монголоор зөв нэрлэхэд зүтгэсэн хүн билээ. ... Б. Содном гуай нь 200 гаруй хэвлэлийн хуудас, 3 боть нэр томьёоны толийг санаачлан боловсруулсан нь одоо монголын нэр томьёо судлалд хэвлэгдсэн хамгийн том бүтээл хэвээр, олон мянган судлаачдын ширээний ном болсоор байна.” (Монгол улсын хүний гавьяат эмч, Анагаахын шинжлэх ухааны доктор, профессор Ж. Раднаабазар “Б. Содном бол анагаах ухааны нэр томьёо үндэслэгчдийн нэг мөн”) гэх зэрэг салбар бүрийн

эрдэмтэн мэргэдийн дурсамж, судалгаа батлан харуулна. Түүгээр ч барахгүй тухайн үед (1962) нь *“Хэл бичгийн судлалыг олон жил хийж байгаа Б. Содном, манай алдарт зохиолч Д. Нацагдоржийн зохиолын түүврийг нягтлан эмхэлж хэвлүүлэв. Содном бас нэр томьёо тогтоох талаар голчлон оролцож их ажлыг хийж байна”* (“Монголын уран зохиолын өв уламжлалын асуудалд” I. ШУАХ. Улаанбаатар., 1987. 115 дугаар тал) хэмээн академич Ц. Дамдинсүрэн түүний хийж бүтээж байсан ажлыг өндрөөр үнэлж байсан бол академич Б. Ринчен ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн цол зэрэг хамгаалах эрдмийн зөвлөлийн хурал (1976. 07. 16) дээр *“Содном нь монголын хэл уран зохиолын судлалд их зүйлийг бүтээж өгсөн. Содном нь ялангуяа Д. Нацагдоржийн зохиолыг судлах хэвлүүлэх талаар их зүйл хийснийг онцлон тэмдэглэхийн гадна орчин цагийн монгол нэр томьёо зохиож хэвшүүлэхэд онцгой хүчин зүтгэсэн юм”* хэмээн үнэлсэн байна.

Төгсгөлийн энэ ботид орсон түүний бичсэн “Тунгалаг нарны хүч”, “Өнчин ишиг”, “Дурсгалын бичиг”, “Тэрэлжийн голын хүүхдүүд” зэрэг шүлэг, өгүүллэг түүнийг багагүй авьяастай нэгэн байсныг харуулах бол Н. В. Гоголийн “Хамар”, И. А. Крыловын “Мигуй ба тогооч”, Ю. Лермонтовын “Далбаа” зэрэг зохиол бүтээлийн орчуулгаас ямар түвшиний орчуулагч байсныг давхар давхар харж болохоор байна.

Эцэст нь тэмдэглэхэд *“Эдгээр гурван ботиос Монгол улсын ХХ зууны ахмад сэхээтний нэг, аман зохиол судлаач, утга зохиолын онолч, утга зохиолын түүхч, хэл шинжлэлтэн, яруу найрагч, үргэлжилсэн зохиолч, орчуулагч, утга зохиолын шинжээч Балданы Содномын шинжилгээ-уран сайхны сэтгэлгээний ертөнцтэй уншигч, судлагч бүхэн танилцах өргөн боломж нээгдэж байна.”* (Д. Цэдэв “Балданы Содномын шинжилгээ-уран сайхны сэтгэлгээний ертөнц”. Балданы Содном “Зохиол судлал”. Тэргүүн боть. Уб., 2008-2009. 30 дугаар тал) Энэхүү өргөн бололцоог ашиглан “БАЛДАНЫ СОДНОМ СУДЛАЛ”-аар дамжуулан ХХ зууны оюун сэтгэлгээний хөгжлийг нарийвчлан авч үзэх явдал хойч үеийнхний өмнө тулгар асуудлын нэгэн болж үлдэнэ. Учир нь өгүүлэн буй ботиуд болоод “БАЛДАНЫ СОДНОМ СУДЛАЛ”-аас ХХ зууны монголын нийгмийн хөгжил дэвшил, монгол хүний оюун бодол, сэтгэлгээний нэгэн үе тодрох нь дамжиггүй.